

МУИС-ИЙН ОЮУТНЫ БАЙГУУЛЛАГА, КЛУБУУДЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ

Чуулганы зорилго:

Оюутны хөгжилд тэдний өөрсдийн оролцоо, санал санаачлагыг хөгжүүлэн дэмжих, оюутны сайн дурын байгууллага, клубуудын үйл ажиллагааг эрчимжүүлж, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чуулганы зорилго оршино.

Чуулганы хэлэлцэх асуудал:

- Оюутны байгууллага, клубуудын төлөөлөх чадвар, тэдний легитим шинж, стандартыг тодорхойлох
- Оюутны хөгжилд өөрийн оролцоог нэмэгдүүлэх арга зам, хэлбэрүүд, клубуудын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох
- Клубуудын хөгжлийн чиглэл, эрхэмлэх зүйлсийг тодорхойлох
- МУИС-Клубын хамтын ажиллагаа, Хамтын ажиллагааны арга хэлбэрүүд
- Оюутны үйлчилгээ, түүнийг сайжруулах нь

Чуулганыг зохион байгуулах арга хэлбэр, формат:

Чуулганыг Оролцооны аргын нэг хэлбэр болох 1. Бүлгийн хэлэлцүүлэг, 2. Эвлүүлгийн аргыг ашиглана. Үүнийг дараах байдлаар зохион байгуулна:

- Хэлэлцэх асуудлаар Түлхүүр илтгэлүүд тавьж, асуулт хариулт өрнүүлнэ.
- Асуулт хариултын дараа оролцогчид бүлэгт хуваагдаж хэлэлцэж буй асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлж, үр дүнг нийт оролцогчдод танилцуулна.
- Бүлгийн хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн шийдлийн хувилбаруудыг боловсруулна.

Чуулганы бэлтгэл ажлыг хангах:

- Зохион байгуулалтын техник асуудлыг МУИС-ийн Оюутны алба хариуцна
- Оюутны оролцоог хангах, идэвхжүүлэх ажлыг МУИСОХ болон Магистр докторын оюутны холбоо хариуцна

Чуулган болох байршил, хугацаа:

- МУИС-ийн Хичээлийн 1-р байр 320 тоот
- 2015 оны 11-р сарын 14-ний 10-14 цаг

ОЮУТНЫ АЛБА

Монгол улсын их сургууль

ЧУУЛГА УУЛЗАЛТЫН ХӨТӨЛБӨР

- 9:30-10:00** Бүртгэл
- 10:00-10:10** Нээлт Р.Бат эрдэнэ, МУИС-ийн Захирал
- 10:10-10:20** Оюутны байгууллага, клубын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаарх МУИС-ийн бодлого, зорилт
Илтгэгч: О.Мөнхбат, Оюутны хөгжил, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал
- 10:20-10:30** “Оюутны байгууллагын үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга зам”
Илтгэгч: МУИСОХ-ын Тэргүүн У.Басбиш
- 10:30-10:40** Оюутны клуб, сонирхлын бүлгийн үйл ажиллагааны талаар:
Илтгэгч: З.Отгонзаяа, ЗХТБиржийн Сургалт хариуцсан ажилтан
- 10:40-11:00** Клубын үйл ажиллагаанд Энтерпренер зарчмыг нэвтрүүлэх боломж бололцоо:
Илтгэгч: Т.Баярцэцэг, МУИС-ийн ШУС, Социологи нийгмийн ажлын тэнхмийн багш, “Сошиал энтрепренёршипийн ойлголт ба интерпрайс төвийн үйл ажиллагаа”
Илтгэгч: Д.Лхагвасүрэн, МУИС, Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтсийн мэргэжилтэн “Сошиал энтрепренёршип ба оюутны оролцоо”
Асуулт хариулт
- 11:00-11:15** Шилдэг клубуудын танилцуулга BEST , Talented students
- 11:15-11:35** Цайны завсарлага
- 11:40-12:40** Бүлгийн хэлэлцүүлэг: Бүлэгт хуваагдан өгөгдсөн сэдвийн дагуу ажиллана. Нэг бүлэгт 10 орчим оролцогч байна. Бүлгээр ажилласаны дараа ижил сэдэв авсан бүлгүүд хоорондоо хэлэлцэж Нэгдсэн хуралд танилцуулах саналаа нэгтгэн танилцуулахад бэлдэнэ.
- 12:40-13:40** Нэгдсэн танилцуулга: Бүлгүүд нэгтгэсэн саналуудаа танилцуулна.
- 13:40-13:50** Хаалтын ажиллагаа
- 13:50-14:00** Дурсгалын зураг татуулах